

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ  
11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл**

2021 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааныг 1, ээлжит хуралдааныг 2 удаа зохион байгуулсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааныг 2021 оны 11 дүгээр сарын дүнгээр 13 удаа хуралдуулж нийт 48 асуудлыг хэлэлцэж 41 тогтоол гаргасан. Тухайлбал, Зохион байгуулалтын асуудлаар-8, Хурлын хороодын үйл ажиллагааг дэмжих асуудлаар-2, Тогтоолд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлаар-3, Орон нутгийн өмчийн асуудлаар-7, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хуваарилалтыг батлах тухай, Хүн амын эрүүл мэндийг дэмжих жил болгон зарлах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дэд зөвлөл байгуулж, дүрмийг батлах тухай, Аймгийн Мал аж ахуйн салбарын бодлого, чиглэлийг батлах тухай, Сум, багийн нэр, дугаарыг уламжлах тухай, Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлийг олгох, хяналт тавих журмыг шинэчлэн батлах тухай, Газар тариалан, хадлан тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээний тариф тогтоох тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд санал өгөх тухай, 2022 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, зориулалт, байршилын саналыг уламжлах тухай, Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид тусламж үзүүлэх тухай, ГХУСАЗСЗ, дэд зөвлөлүүдийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай, Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр батлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж тогтоол гаргасан байна.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн Удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөнийг 11 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газарт зохион байгуулж, хуваарийн дагуу Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын удирдлагууд тухайн сарын хэрэгжүүлсэн ажил, анхаарах асуудлыг танилцуулж, цаг үеийн асуудлын талаар хэлэлцэж, аймгийн Засаг дарга хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг даалгавар өгсөн.

Мөн өдөр аймгийн удирдлагууд, хэлтэс, агентлагийн дарга нар 19 сумын Засаг дарга нартай цахим хурал хийсэн.

Төсвийн тухай хуулийн 8.5.1-п заасны дагуу аймгийн Засаг дарг М.Батжаргал 2022 оны жилийн төсвийн төслөө 11 дүгээр сарын 25-ны өдөр хуулийн хугацаанд нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад Б.Батжаргалд өргөн барьсан.

2021 оны 11 дүгээр сарын 15,16-ны өдрүүдэд Архангай аймагт Төрийн албаны ерөнхий шалгалтыг амжилттай зохион байгуулса бөгөөд төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр нийт 243 иргэн бүртгүүлснээс, 203 иргэн шалгалтад орж 64 иргэн тэнцсэн байна.

Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний үйл ажиллагааг менежментийн өндөр түвшинд хүргэх, байгууллагын ажил үйлчилгээг сайжруулах зорилгоор аймгийн ЗДТГ-т Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэхээр ажлын хэсэг байгуулагдан, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа бөгөөд 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр аймгийн ЗДТГ-ын ажилтан, албан хаагчид хуваарийн дагуу ээлжит сургалтандаа хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан журмын дагуу 2021-2022 оны хичээлийн жилд магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд суралцаж буй бүтэн өнчин 8 суралцагчийн нэгдүгээр хагас жилийн тэтгэлэгт тус бүр 500.0 мянга, нийт 4.0 сая төгрөгийг олгосон байна.

2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар PCR-аар шинжилсэн 74 сорьцноос 17, түргэвчилсэн оношлуурын 23 шинжилгээнээс 7, нийт 24 тохиолдол батлагдсан байна. Тодруулбал: Хотонт-2, Цэнхэр-2, Булган-2, Эрдэнэбулган-18, 2021 онд батлагдсан нийт 12342 тохиолдол байна.

214 хүн тусгай эмнэлгүүдээс, өрхийн эмнэлгийн хяналтад гэрээр эмчлүүлэгч 40, Сумдад гэрээр эмчлүүлэгчдээс 7, нийт 261 хүн эдгэрсэн. Нийт тохиолдлын 12258 буюу 99,3% нь эдгэрсэн. Нийт нас баралт: 39, Эмчлүүлж байгаа 226: Үүнээс: тусгай эмнэлгүүдэд – 182, Биеийн байдал: Хөнгөн 136, хүндэвтэр 40, хүнд 6, ӨЭМТ-үүдийн хяналтад гэрээр эмчлэгдэж байгаа 37, Ар Мөнгөнчагнуур - 17, Ар Мөнхжин - 14, Ар Манал – 6, Сумдад гэрээр эмчлэгдэж байгаа: 7, Эмчлүүлэгчдийн нас: 0-5 нас: 27, 6-15 нас: 54, 16-39 нас: 67, 40-59 нас: 51, 60-аас дээш: 27, Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын гэрийн тусгаарлалтад – 686, Аймгийн хэмжээнд I тунд 60501, II тунд 56927, III тунд 18670 хүнийг дархлаажуулсан байна.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт**

2021 оны 11 дүгээр сард орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 135.0 сая төгрөг, аймгийн төсөвт 10926.0 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Хөдөлгөөнт пос машинаар 7699 татвар төлөгчийн 410.0 сая төгрөг, ибаримтаар 3015 татвар төлөгчийн 37.8 сая төгрөгийг улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

### **Хөрөнгө оруулалт**

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ батлагдсанаас орон нутагт 22.293.7 сая төгрөгийн эрх шилжижи ирснээс 2021 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар 12.697.7 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 1.697.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсанаас 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 127.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

### **Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа**

Орон нутгийн өмчит 30 төсөвт байгууллагад 59.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 10 төсөвт байгууллагад 48.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх, зөвшөөрлийг олгосон 25 байгууллагад 358 нэр төрлийн 374.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Орон нутгийн өмчийн газар 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар хугацаанд нийт 754.4 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан.

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн нутаг дэвсгэрт байршилтай зоорийн давхарт үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжуудад Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт шалгалтыг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

Шалгалтаар “Хан-Оюут” ХХК, “Тансаг трейд” ХХК-ны тавилгын худалдаа, “Гост трейд” ХХК-ны гэр ахуйн бараа, “Бүрэн-Ар” ХХК-ийн Тоскын байрны доод талд байрлах салбар агуулах, Цагдаагийн газрын мөрдөн шалгах, түр саатуулах байр, Мэргэжлийн хяналтын газрын лаборатори, “Найруулга” ХХК-ны махны агуулах, “Ундррам” ХХК-ны

тавилгын худалдаа, “АРА” засварын төв, “Ар арвис” тавилгын худалдааны газар зэрэг нийт 10 объект хамрагдаж Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, норматив, дүрэм, журмын холбогдох заалтыг зөрчсөн 54 зөрчил илрүүлж, 23 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 5, мэдэгдэл 5-ыг тус тус бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, ахуйн ариун цэврийг сахих, амны хаалт зүүх, бага насны хүүхдийг олон нийтийн газраар дагуулан явахгүй байх, үер усны ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 3 удаагийн цахим зайн хичээлийг орон нутгийн телевизээр өдөрт 2 удаагийн давтамжтайгаар 80 минут цахим сургалтыг зохион байгууллалаа.

2021 оны 11 дүгээр сард Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх анхааруулах 3 мэдээг ОБЕГ-ын ГШУГ-аас хүлээн авч орон нутгийн УЦУАлбанаас тодотгож давхардсан 19 сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, цаг уурчид нийт 6540 алба хаагчдад багц мессежээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэл өгч, орон нутгийн “АВ”, “Тамиры”, телевизээр сэрэмжлүүлгийг урсдаг зар хэлбэрээр өдөрт 6 удаа, 8 удаагийн давтамжтай нийт 864 удаа иргэдэд нэвтрүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаа.

Онцгой байдлын газрын холбооны 10 нэр төрлийн 77 техник хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийг цэвэрлэгээ, үзлэг, засварыг хийж антены бэхэлгээг давхар шалгаж, ТҮ-г хуваарийн дагуу хийж, 3 алба хаагчийн компьютерыг засварлан хэвийн ажиллагааг хангаж, гар станц болон машины станц, GPS 60CSx, сансрын IRIDIUM утас бэлтгэл бэлэн байдлыг ханган ажилласан.

#### **Гал түймрийн зөрчил:**

Эрдэнэбулган сумын 7-р баг Тамир хорооллын 26-28 тоотод 2021.10.29-ний өдөр байшингийн нам даралтын зуухны өрөө шатаж байна гэсэн дуудлагаар ГТУА 51 дүгээр ангиас 5 алба хаагч, 1 автомашинтай очиход иргэд өөрсдөө унтраасан байна.

#### **Зам тээврийн ослын дуудлага:**

Цэнхэр сумын Алтан-Овоо багийн Янгиртай хясаа гэдэг газар 2021.10.29-ний өдөр зам тээврийн осол гарч, ОБГ-аас 7 хүн, 1 техник хэрэгсэлтэй ажиллаж аюулгүй болгон, 1 буцалтгүй нэрвэгдэгчийг гаргаж цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

#### **Эрэн хайх, аврах ажиллагаа:**

Төвшрүүлэх сумын “Нуурын дэнж” гэдэг газар иргэн “Ё”-ын “Тоёота Ист” загварын 85-21 АРА автомашин 2021.11.06-ны өдөр “Дунд нуурын” мөсөнд цөмөрснийг дуудлага өгсөний дагуу ОБГ-аас 7 алба хаагч, 1 автомашинтай очиж аврах ажиллагааг зохион байгуулсан байна.

2021 оны 11-р сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 384 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 120, хулгайлах гэмт хэрэг 121, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 41, малын хулгайн гэмт хэрэг 60, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 25, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 103, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 30, гэмт хэргийн илрүүлэлт 60.8 хувьтай байна.

Нийт 18192 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 17374 иргэнд 674374.8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1293.0 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 54.1 хувьтай байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар шинээр баригдаж буй барилга байгууламж 28, инженерийн шугам сүлжээний ажил 1, их засвар хийсэн 1 барилга байгууламжуудад хяналт шалгалт хийлээ. Барилгын угсралтын ажлыг баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгээгүй 4 барилга байгууламжийн угсралтын ажлыг улсын байцаагчийн актаар зөрчил арилгах хүртэл хугацаагаар түр зогсоож, хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 1 орон сууцны барилгад улсын байцаагчийн 2 заалттай албан шаардлага хүргүүллээ.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс Батцэнгэл, Эрдэнэбулган, Ихтамир сумдаас тохирлын гэрчилгээ сунгуулах материал ирүүлсэн хүсэлтийн дагуу үнэлгээ хийж, жижиглэн худалдаа 4, зочид буудал-1, хоол үйлдвэрлэл 2 нийт 7 газрыг баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тохирлын гэрчилгээг олгохоор шийдвэрлэлээ.

## **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд**

### **Боловсрол**

2021-2022 оны хичээлийн жилийн Боловсролын салбарын статистик мэдээлэл гарч БШУЯам Үндэсний статистикийн хороонд хүлээлгэн өгөв. Энэхүү хичээлийн жилд Архангай аймагт 32 ерөнхий боловсролын сургууль /төрийн 30, хувийн өмчийн 2/, 36 хүүхдийн цэцэрлэг /төрийн өмчийн 35, хувийн өмчийн 1 цэцэрлэг/ тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улаан бүсэд тооцогдож байсан ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн түвшин шар бүсрүү шилжин 5 хоног танхимаар, 9 хоног цахим хичээлийн хэлбэрт шилжив.

Шар бүсэд харъяалагдаж байсан сумдын ерөнхий боловсролын сургуулиуд 100% танхимын сургалтын үйл ажиллагаанд шилжлээ.

### **Соёл**

Аймгийн Нийтийн номын сан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед уншлагын танхимын 50 хувийн дүүргэлттэй халдвар, хамгааллын дэглэмийг мөрдөн танхимын үйлчилгээ хүргэн ажиллаж байна.

Нийтийн уншлагын танхимаар 26 ирэгсэдэд 105 ном, 123 сонин сэтгүүл, Хүүхдийн уншлагын танхимаар 39 уншигч шинээр бүртгэж, 498 ирэгсэдэд 644 ном, гэрээр ном олголтоор 3 уншигч шинээр бүртгэж, 123 ирэгсэдэд 163 номоор тус тус үйлчилсэн байна. Номын сангийн MonKoha үүлэн технологийн программд ном шивэх ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд үндсэн фондын 63 нэрийн 542 ширхэг номыг шивж, бар коджууллаа.

“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Архангай аймагт “Номын баяр” арга хэмжээг 11 дүгээр сарын 29,30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Архангай аймгийн ЗДТГ, Нийтийн номын сан хамтран зохион байгуулсан “Номын баяр” арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн сурагчдад эссе бичих тухай, хүүхдийн зохиолын чиг хандлага, ном бичихэд анхаарах зүйлсийн талаар лекц тавигдсан бол төрийн албан хаагч, номын санчдад Төрөөс баримтлах номын бодлого, шинэ уран зохиол ба уншигчдын тухай лекцүүд орлоо.

### **Эрүүл мэнд**

Архангай аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, УИХ-ын гишүүн, Монгол Улсын гавьяат эмч Ж.Чинбүрэнгийн хамт "Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх нярайн яаралтай тусламж" сургалтыг санаачлан НҮБ-ын хөтөлбөртэй хамтран аймагт зохион байгуулж байна.

Эх нярайн эрүүл мэнд, яаралтай тусламж үйлчилгээний чанарын асуудлаар 11 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд үргэлжилсэн сургалтад УИХ-ын Тамгын газар, Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүн амын сан, ЭХЭМҮТөв, аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн төлөөлөл, мөн бүх сумын эх баригч, нярайн эмч, эмэгтэйчүүдийн эмч нар оролцлоо.

Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банкны "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5, Ковид19-ийн нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд 1.4 тэрбум төгрөгийн өртөгтэй арилгын их засвар, тоног төхөөрөмж бүхий Төвлөрсөн ариутгалын тасаг орчин үеийн дэвшилтэт лабораторийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт байгууллаа.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал**

2021 оны 11 сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1152 иргэн бүртгэлтэй байгаагаас 560 эмэгтэй. Шинэ ажлын байр 936 үүнээс байнгын ажлын байр 468, улирлын ажлын байр 205, түр ажлын

байр 263 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 828, зуучлал 795 байна. Тухайн сарын 19-ны байдлаар 147 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 12, бага- 50, суурь-218, бүрэн дунд- 637, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 21, тусгай мэргэжлийн дунд- 27, Дипломын бакалаврын-187 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 17 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч Нийгмийн даатгалын хэлтэс рүү хүргүүлсэн.

"Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"- ийн Шилдэг "Старт-ап" залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарсан залуучуудын "Эко түлш" бүлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж бизнесээ хөгжүүлэх, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл авахад нь зориулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эргэн төлөгдөх нөхцөлгүй 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олголоо.

Хүнсний эрхийн бичиг олгох шинэчлэгдсэн журмын дагуу улсын хэмжээнд хүнсний эрхийн бичгээр олгох бүтээгдэхүүнийг /10 нэр төрлийн бүтээгдэхүүн/ зураасан коджуулж, системийн хөгжүүлэлт хийсэн дурын аж ахуйн нэгж, томоохон зах, худалдааны төвөөр дамжуулан үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажил хангагдаад байна. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд 35 дэлгүүр системийн хөгжүүлэлт хийлээ.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2021 оны 11 сарын байдлаар нийт 16553 тэтгэвэр, тэтгэмж авагчдад 49,4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн хугацаанд шуурхай олгож ажилласан байна.

### **Гэр бүл, хүүхэд, залуучууд**

Хүүхэд багачуудад төрөлх нутгийнхаа түүх, соёлоор бахархах, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, тэдний хөгжил оролцоог дэмжиж, нутгийн өвөрмөц соёлын өвийг хүүхэд залууст уламжлуулах, нутагшуулах зорилготой "Бид-Архангайн Ирээдүй" арга хэмжээний анхан шатны сургалт болох үе тэнгийн сургагч бэлтгэх сургалтыг Эрдэнэбулган сумын 2,3,4,5-р сургуулийн ангийн ахлагч нарт зохион байгууллаа.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд "ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" Үндэсний аяныг 21 аймаг, 9 дүүрэг, 330 суманд 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр зохион байгуулж байна. Өсвөр үе, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын төлөөллүүд болох Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нийт 75 алба хаагчид оролцлоо.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд**

#### **Мал аж ахуй**

"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 11, ОНХС-ийн хөрөнгөөр "Би ди икс инженеринг" ХХК-ийн гүйцэтгэсэн 8, нийт 19 худгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/709 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэг ашиглалтад хүлээн авлаа.

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой энгийн механик, биологийн аргаар тэмцэх үйл ажиллагааг 25.2 мянган га талбайд, үүнд Хашаат 8000 га, Цэцэрлэг 8000 га, Өлзийт 4600 га, Өгийнуур 4600 га талбайд тус тус зохион байгуулж байна.

Аймгийн 19 сумын 101 багийн 3.7 сая га бэлчээрт 8207 хот айлд 17.1 мянган малчин болон мал бүхий өрхийн 5862.0 сая орчим толгой малыг өвөлжүүлж байна.

Малчдын түвшинд 80 мянган тн өвс, 1300 тн гар бэлтгэхээс өнөөдрийн байдлаар 71.2 мянган тн өвс, 100 тн сүрэл, 3484 тн ногоон тэжээл, 54 тн үйлдвэрийн тэжээл, 1183 тн гар тэжээл, 517 тн давс, хужир шүүг бэлтгэн хадлан бэлтгэл 98,8 хувьтай байна. Аймаг сумын аюулгүйн нөөцөд 2950 тн өвс, 1100 тн тэжээл, 400 тн ногоон тэжээл бэлтгэхээс 1539.4 тн өвс, 1151.2 тн ногоон тэжээл, гар тэжээл бэлтгэн бэлтгэл аюулгүй нөөц бэлтгэл аймгийн хувьд 81 хувьтай байна.

## **Газар тариалан**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хурлаар "Газар тариалан, хадлан тэжээл, бэлтгэх, техник, тоног төхөөрөмжийн түрээсийн үнэ, тариф тогтоох тухай" асуудлыг хэлэлцэн баталлаа.

"Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд Техник дундын үйлчилгээний төв шинээр байгуулагдаж, цаашид газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд төдийгүй малчид, иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээсээр үйлчлэх юм. Тарифын үнийн хувьд хагалгаа, шууд хураалт тус бүр 80000 төгрөг, сийрүүлэх /хавах/, борнойдох, булдах, үр тариа үрлэх, цайруулах тус бүр 50000 төгрөг, хор цацах-40000, үр тариа ачих, тариа цэвэрлэх тус бүр 5000 төгрөг /1тн/, бордоо цацах 35000 төгрөг, тэжээл, өвс боох 1000 төгрөг /1 боодол/, хадах, тармах 60000 төгрөг байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Эрдэнэбулган суманд 50-60 тн-ийн багтаамжтай төмс, хүнсний ногоо хадгалах зоорийг барьж ашиглалтанд орууллаа.

## **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

### **Байгаль орчин**

Аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А /616 дугаар захирамжийн дагуу Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалт, сумдын ундны ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоох ажлыг Орхон-Чулуут голын сав газрын захиргаагаар гүйцэтгүүлээ.

Аймгийн хэмжээнд 1345 гол горхи, нуур тойром, булаг шанд болон сумын төвийн ундны усны эх үүсвэрийн 103 ширхэг худагт хамгаалалтын бүсийг тогтоолоо. Хамгаалалтын бүс тогтоосон хээрийн ажлын үр дүнг сумдад танилцуулан орон нутгийн саналыг нэгтгэн БОАЖЯ-нд дүгнэлт гаргуулахаар хүргүүлээ.

### **Барилга, дэд бүтэц, газар**

2021 оны 11-р сард дараах барилгуудад үе шатны хяналт хийсэн. Үүнд:

- ✓ Булган сумын Соёлын төвийн барилгын ажил. Гүйцэтгэл 80%
- ✓ Жаргалант сумын Соёлын төвийн барилгын ажил. Гүйцэтгэл 80%
- ✓ Хашаат сумын Сургуулийн өргөтгөлийн барилгын ажил эхэлсэн. Гүйцэтгэл 85%
- ✓ Чулуут сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажил-гүйцэтгэл-90%
- ✓ Өндөр-улаан сумын Хануй багийн бага сургуулийн барилгын ажил эхэлсэн. Гүйцэтгэл 100%
- ✓ Булган сумын Сургуулийн барилгын засвар тохижилтын ажлын гүйцэтгэл 100%.
- ✓ Төвшрүүлэх сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил-Гүйцэтгэл-30%
- ✓ Цэнхэр сумын Цэнхэр багийн төвийн конторын барилгын ажил эхэлсэн-гүйцэтгэл -100%
- ✓ Жаргалант сумын Асайт багийн конторын барилгын ажил-Гүйцэтгэл -100%
- ✓ 1-р сургуулийн өргөтгөлийн барилга-гүйцэтгэл-100%
- ✓ 300 ортой эмнэлгийн барилга угсралтын ажил-35%
- ✓ Чулуут сумын соёлын төвийн барилга-90%

Эрдэнэбулган сумын Ирээдүй цогцолбор сургуулийн халаалтын тогооны өргөтгөлийн ажил, Эрдэнэбулган сумын улсын чанартай зам дагуу ногоон байгууламж хашаа барих ажил, Эрдэнэбулган сумын 6-р багийн Эмнэлэгийн барилгын засварын ажлын гэрээг тус тус шинээр байгуулсан.

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн дараах 9 барилгыг ашиглалтанд хүлээн авах комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан байна. Үүнд:

1. Жаргалант сумын сургуулийн их засварын ажил

2. Ирээдүй сургуулийн уурын зуухны засварын ажил
3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ариун цэврийн байгууламж, гадна ариутгах татуурганы шугамын ажил
4. Булган сумын Эрүүл мэндийн төвийн гадна, дотор бохир, цэвэр усны байгууламжийн ажил
5. Хотонт сумын өвс тэжээлийн агуулах саравчны барилгын
6. Өндөр-Улаан, Чулуут, Булган, Хангай, Ихтамир, Батцэнгэл сумдад Харилцаа холбооны цамхагийн байгууламж барих ажил
7. Хашаат сумыг шилэн кабелд холбох 45 км ажилд
8. Хайрхан сумын Эрүүл мэндийн төвийн барилга
9. Иргэн М.Батболдын 37 айлын орон сууцны барилга

Барилгын материалын лаборатори нь 2021 оны 11-р сарын байдлаар давхардсан тоогоор 81 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 160 дээжинд сорилт шинжилгээ хийн үр дүнг хүлээлгэн өгч 100010029401 тоот дансанд 4378300 төгрөг төвлөрүүлээд байна.

### **Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээ**

Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд “Ажлын байрыг дэмжих” зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож байна. Үүнд:

- “Хаан” банк 117 иргэн, аж ахуйн нэгжид 7,4 тэрбум төгрөг,
- “Төрийн” банк 46 иргэн, аж ахуйн нэгжид 9.0 тэрбум төгрөг,
- “Хас” банк 21 иргэн, аж ахуйн нэгжид 1.2 тэрбум төгрөг,
- “Голомт” банк 20 иргэн, аж ахуйн нэгжид 1,4 тэрбум төгрөгийн зээлүүдийг тус тус олгосон.

Ажлын байрыг дэмжих зээлийг 353 иргэнд 11,7 тэрбум төгрөг, 64 аж ахуйн нэгжид 9,7 тэрбум төгрөг, нийт 417 иргэн, аж ахуйн нэгжид 21,4 тэрбум төгрөгийн зээл олгож 823 ажлын байрыг хадгалсан байна.

Хөдөө аж ахуйг дэмжих зээлийг олгож эхлээд байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 1161 малчинд 14,2 тэрбум төгрөг, газар тариалангийн чиглэлээр 3 иргэн, аж ахуйн нэгжид 160.0 сая төгрөгийн зээл тус тус олгоод байна.

2020 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт жилийн эцсийн байдлаар 700.8 сая төгрөг орж ирсэн бол 2021 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт энэ оны эхний хагас жилийн байдлаар 989,3 сая төгрөг орж ирсэн байна. 2020 онд сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийг Цэнхэр, Хангай, Өндөр-Улаан сумын 65 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд 240.0 сая төгрөгийн зээл олгож 98 ажлын байр бий болсон байна.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

-----oOo-----